



ДОРНОД АЙМГИЙН
БОЛОВСРОЛЫН
ГАЗАР

ЭЛСЭЛТИЙН ШАЛГАЛТ-2025

МОНГОЛЫН ТҮҮХ Онлайн сорил-3

2 сарын 22 18.00-19.20

1.

I. Дараах дурсгалуудын аль нь Хуучин чулуун зэвсэг (Палеолит)-ийн үед хамаарах вэ? (1 оноо)

- A. Чандманий соёл
- C. Норовлингийн суурин
- E. Тэвш уулын хадны зураг

- B. Можоогийн хадны зураг
- D. Ишгэн толгойн хадны зураг

2.

. Дараах түүхийн дурсгалуудыг орших газар нутагтай нь тохируулна уу? (2 оноо)

- 1. Мойлтын ам
- 2. Ярх уул
- 3. Ишгэн толгой
- 4. Рашаан хад

- a. Өвөрхангай аймгийн Хархорин сум
- b. Дундговь аймгийн Гурвансайхан сум
- c. Ховд аймгийн Манхан сум
- d. Хэнтий аймгийн Батширээт сум

- A. 1-a, 2-b, 3-c, 4-d
- C. 1-a, 2-b, 3-d, 4-c.

- B. 1-c, 2-d, 3-a, 4-b.
- D. 1-b, 2-a, 3-c, 4-d.
- E. 1-d, 2-b, 3-c, 4-a

3.

3. Хүмүүс байгалийн бүтээгдэхүүнийг бэлнээр нь хэрэглэхээ больж үйлдвэрлэж хэрэглэж эхэлсэн байна. Аль үед хамаарах вэ? (2 оноо)

- A. Палеолит
- D. Энеолит

B. Мезолит

- C. Неолит
- E. Хүрэл зэвсэг

4.

4. Чулуун зэвсгийн хүмүүсийн тариа цайруулах зориулалтаар хэрэглэдэг байсан зүйлс аль нь вэ? (2 оноо)

- A. Уур, нүдүүр
- C. Хүрз, зээтүү

- B. Чулуун самбар, нухуур
- D. Чулуун ялтас, залтас

E. Чулуун зуулга зэвсэг

5.

5. Монголын түүхэн дэх “Зэс чулууны үе” гэдэгт дараах нэршлүүдээс аль тохирох вэ? (1 оноо)

A. Неолит
C. Энеолит

D. Палеолит

B. Мезолит
E. Хүрэл зэвсэг

6.

6. Хүрэл зэвсгийн үеийн хадны зургуудыг орших газар нутагтай нь зөв тохируулна уу? (2 оноо)

1. Тэвш уулын хадны зураг
2. Толжийн боомын хадны зураг
3. Баянлигийн хадны зураг
4. Их Тэнгэрийн амны хадны зураг

- a. Өвөрхангай Богд сум
- b. Хөвсгөл аймаг Улаан-Уул сум
- c. Баянхонгор аймгийн Баянлиг сум
- d. Улаанбаатар хотын орчим

A. 1-b, 2-d, 3-a, 4-c.
D. 1-a, 2-b, 3-c, 4-d.

B. 1-d, 2-b, 3-c, 4-a.
E. 1-b, 2-a, 3-c, 4-d.

C. 1-a, 2-d, 3-c, 4-b.

7.

7. Дараах хот суурингийн дурсгалуудаас аль нь Хүннүгийн үед хамаарахгүй вэ? (1 оноо)

A. Гуа дов
D. Чин толгойн балгас

B. Иволгийн суурин
E. Тэрэлжийн Дөрвөлжин

C. Бүрхийн дөрвөлжин

8.

8. Сяньби нар дайсныхаа толгойн оройн хуйхыг өвчин авдаг байсан аж. Үүнийг хэрхэн нэрлэдэг вэ? (2 оноо)

A. Гавал авах ёс
D. Сүлд авах ёс

B. Хуйх авах ёс
E. Сэвлэг авах ёс

C. Тоног авах ёс

9.

9. Сяньби нарын хойч үе Тобагийн Вэй улс хэдэн онд байгуулагдсан бэ?

(1 оноо)

A. НТ 198 он

B. НТ 48 он

C. НТ 235 он

D. НТ 313 он

E. НТ 200 он

10.

10. Жужаны түүхийг судлан “Монгол Нирун улс” хэмээх зохиолыг 1992 онд бичсэн түүхч аль нь вэ? (1 оноо)

A. Х.Пэрлээ

B. Ц.Хандсүрэн

C. Ц.Доржсүрэн

D. А.Очир

E. Г.Сүхбаатар

11.

11. Жужан улсыг мөхсний дараа “Эргүнэ хун” хэмээх газарт Жужаны нэг хэсгийг ямар аймгууд тэргүүлэн аваачсан бэ? (2 оноо)

A. Нукуз, Хиан

B. Хиад, Боржигин

C. Лань, Сюйбюй

D. Татар, Найман

E. Тайчууд, Мэргэд

12.

12. Түргүүдэд захирагдахыг үл хүсч Өрнө зүг нүүсэн нэгэн хэсэг Жужан (Нирун) нар 558 оны үеэс Европын судар бичгүүдэд ямар нэрээр тэмдэглэгдэх болсон бэ? (1 оноо)

A. Гунну

B. Варвар

C. Авар

D. Мажар

E. Хүннү

13.

13. Монгол нутагт эрхшээн өөрийн төрт улсаа байгуулан, оршин тогтнож байсан Уйгур нарын өвөг дээдэс баруун, зүүн гэсэн хоёр хэсэгт хуваагддаг байсан бөгөөд зүүн хэсэг нь Байгаль нуурын урдуур, Сэлэнгэ, Орхоны саваар нутагладаг байсан гэвэл баруун нь хаана нутаглан суудаг байсан бэ? (1 оноо)

А. Алтай нуруу, Чүй гол

В. Тэнгэр уул, Долоон ус

С. Хянганы нуруу, Эргүнэ гол

Д. Эрчис мөрөн, Балхаш нуур

Е. Хөх нуур, Төвд

14.

14. Энэхүү зураг дээрх дурсгал хаана байдаг түүхийн дурсгал вэ? (2 оноо)

А. Архангай аймгийн Хашаат сумын нутаг Күлтегиний гэрэлт хөшөө

В. Увс аймгийн орон нутаг судлах музейд буй Долоодойн гэрэлт хөшөө

С. Дорнод аймгийн Халх гол сумын Шонх таван толгойн хөшөө

Д. Хөвсгөл аймгийн Бүрэнтогтох сумын Мөнх хааны гэрэлт хөшөө

Е. Төв аймгийн Эрдэнэ сумын нутаг, Тоньюкүкийн гэрэлт хөшөө



15.

15. Булган аймгийн Сайхан сумын Могойн Шинэ ус хэмээх газар нэгэн хаанд зориулж гэрэлт хөшөө босгосон гэвэл энэ хаан хэн бэ? (2 оноо)

A. Кюлүг их Тархан
C. Билгэ

D. Күтүлүг

B. Моюунчур
E. Яглакар Инал

16.

16. “Монголын нууц товчоо”-нд Хаад, Удуйд, Увас гэсэн Гурван Мэргэд гарах бөгөөд Удуйд мэргэдийг Тогтоа Бэх, Увас Мэргэдийг Дайр Үсүн захирч байжээ. Хаад мэргэдийг хэн захирч байсан бэ? (1 оноо)

A. Их Чилэдү
C. Үсүн бэх

D. Хаатай Дармала

B. Чилгэр бөх
E. Үсүн өвгөн

17.

17. Ромын Папад илгээсэн захидалд дарсан, эдүгээ Ватиканд хадгалагдаж буй дурсгал аль нь вэ? (1 оноо)

A. Өгөдэй хааны тамганы дардас
C. Мөнх хааны тамганы дардас
E. Бат хааны тамганы дардас

B. Гүюг хааны тамганы дардас
D. Хубилай хааны тамганы дардас

18.

18. “Монголын нууц товчоо”-нд Өгөдэй хааны 4 сайн үйл хэмээн, “... Өртөө улааг байгуулав, Алтан улсыг эзлэв ... ” гэх зэргээр өгүүлсэн байдаг. Үлдсэн хоёр сайн үйл аль нь вэ? (2 оноо)

A. 1. Бүх хятадыг нэгтгэсэн, 2. Бүх шашныг хүлээн зөвшөөрсөн
B. 1. Өмнөд Сүн улсыг эзэлсэн, 2. Бор гөрөөсийг хашаалсан
C. 1. Усгүй газар худаг усыг гаргасан, 2. Бор дарснаас татгалзсан
D. 1. Даргач тамгач нарыг суулгасан, 2. Өмнөд Сүн улсыг бүрэн эзэлсэн
E. 1. Даргач тамгач нарыг суулгасан, 2. Усгүй газар худаг усыг гаргасан

19.

19. “Монголын нууц товчоо”-ны төгсгөлд “... Их хуралдай болж жилийн сард Хэрлэнгийн хөдөө арал Долоон болдог, Шилхинцэг хоёрын завсар хаан орд бууж байхад бичиж төгсгөв” хэмээн гардаг. Цэгийн оронд тохирох зөв хариултыг сонгоно уу? (2 оноо)

А. Луу, Долоо
С. Морь, Гурван

В. Үхэр, Бар
D. Хулгана, Хуран

Е. Бар, Луу

20.

20. Хубилай хаанд төрийг засах “Хоёр ёсны онол”-ыг зөвлөсөн хүн аль нь вэ? (2 оноо)

А. Төвд лам Пагва
С. Хятад түшмэл Хао Цзин
Е. Сартуул түшмэл Мухаммед Ялавач

В. Хятад түшмэл Жоа Бин
D. Зүрчид түшмэл Елюй Чуцай

21.

21. Персийн түүхч Рашид-Ад-Диний зохиосон түүхийн зохиол аль нь вэ? (1 оноо)

А. Дорно этгээдэд зорчсон тэмдэглэл
С. Орчлонгийн элдэв сонин
Е. Судрын чуулган

В. Ертөнцийг байлдан дагуулагчийн түүх
D. Монголчуудын түүх

22.

22. Монголын Юань улс 1260-1368 оны хооронд оршин тогтнож байсан гэвэл хэдээс хэддүгээр зуун бэ? (1 оноо)

А. XI-XIII зуун
С. XIV-XV зуун

D. XIII-XIV зуун

В. XII-XIII зуун
Е. X-XI зуун

23.

23. Монголчууд “Хашин улс” гэж аль улсыг нэрийдэж байсан бэ? (1 оноо)

А. Солонгос улс
С. Япон улс

D. Өмнөд Сүн улс

В. Тангуд улс
Е. Хорезм

24.

4. Юань гүрний үед Монгол эрдэмтэн Чойжи-Одсэрийн бичсэн зохиол аль нь вэ? (2 оноо)

A. Алтан дэвтэр

B. Монголын нууц товчоо

C. Юань улсын судар

D. Цагаан түүх

E. Зүрхэн тольт

25.

25. 1449 оны Түмүгийн хэрэг хэмээн түүхэнд үлдсэн Мин улс ба Монгол улсын хооронд болсон дайны үед Мин улсын хэн гэдэг хааныг олзлон авсан бэ? (2 оноо)

A. Ин Түн

B. Юн Лэ

C. Жу Юань Жан

D. Ин Зун

E. Вань Мэн

26.

6. Мандуул хааны бага хатан Мандухай уг гарлын хувьд аль түмний аль отгийн хүн бэ? (2 оноо)

A. Халхын Энгүд Отог

B. Цахарын Хулбад отог

C. Халхын Цоохор отог

D. Түмэдийн Татгалжин отог

E. Халхын Хөхүйд отог

27.

27. 1514-1517 онд Барсболд мэргэн жонон төрийн эрхийг түр хамаарсан нь дараах учиртай. Зөв хариулт аль нь вэ? (2 оноо)

A. Мин улсын явуулга байсан учир

B. Даян хааны гэрээс ёсоор

C. Даян хааны хөвгүүдийн ахмад нь учир

D. Баруун гурван түмнийг захирч байсан тул

E. Бодь-Алаг сайн хаан нас бага байсан учир

28.

28. Халхын Анхдугаар богд Өндөр гэгээн Занабазар 1686 онд хоёр үсэг зохиосон бөгөөд нэг нь "Хэвтээ дөрвөлжин үсэг" гэвэл нөгөө нь ямар үсэг вэ? (1 оноо)

A. Тод үсэг

B. Али Гали үсэг

C. Худам Монгол үсэг

D. Соёмбо үсэг

E. Вагиндрагийн үсэг

29.

9. Дараах түүхэн үйл явдлыг он дарааллын дагуу зөв эрэмбэд оруулна уу? (2 оноо)

1. Улиастайн жанжны газар байгуулагдав.
2. Гадаад Монголын Төрийг Засах Явдлын яам байгуулагдав.
3. Ховдын сайдын газар байгуулагдав
4. Хүрээ сайдын газар байгуулагдав.

A. 3, 1, 4, 2 B. 4, 3, 2, 1 C. 2, 4, 1, 3 D. 2, 3, 4, 1 E. 2, 1, 4, 3

30.

0. 1617 онд Лигдэн хутагт хаан Авга хар нэрт ууланд байгуулсан хот аль нь вэ? (1 оноо)

A. Цагаан хот B. Хөх хот
C. Улаан хот D. Шар хот E. Хар хот

31.

1. Цэвээнравдан хааны дараа Зүүнгарын хаант улсын хаан ширээнд хэн суусан бэ? (1 оноо)

A. Цэвээндоржнамжил B. Амарсанаа
C. Даваач D. Ламдаржаа E. Галданцэрэн

32.

32. Чин гүрний үеийн Халх Монгол олон хошуудын засаг ноёд нь уг гарлын хувьд таван янз байсны 3 нь Боржигин, Цорос, Их Мянган бол үлдсэн хоёр аль нь вэ? (2 оноо)

A. Дөрвөд, Баяд B. Хошууд, Торгууд
C. Хойд, Захчин D. Хотон, Сартуул E. Торгууд, Урианхай

33.

33. Манж Чин гүрний эсрэг тэмцэж байсан дараах зүтгэлтнүүдийн хэн нь Орос улсад зугтан гарч удалгүй таалал болсон бэ? (1 оноо)

A. Цахарын Лигдэн хаан B. Хотгойдын Чингүнжав C. Халхын Цогт тайж
D. Хойдын Амарсанаа E. Өөлдийн Галдан бошгот

34.

4. Халхын шашны тэргүүн Анхдугаар Богдод зориулан барьсан хийд аль нь вэ? (1 оноо)

A. Манзушир хийд

B. Дамбадаржаалин хийд

C. Түгээмэл амаржуулагч хийд

D. Амарбаясгалант хийд

E. Эрдэнэ зуу хийд

35.

35. 1911 онд Богд хаант Монгол улсын Гадаад хэргийг бүгд ерөнхийлөн шийтгэх яамны сайдаар хэн томилогдсон бэ? (1 оноо)

A. Сайн ноён Намнасүрэн

B. Түшээ гүн Чагдаржав

C. Да лам Цэрэнчимэд

D. Засаг гүн Гомбосүрэн

E. Хошой чин ван Ханддорж

36.

36. 1913 оны эцэс, 1914 оны эхээр Ерөнхий сайд Т.Намнансүрэн тэргүүтэй төлөөлөгчид аль улсад айлчилсан бэ? (2 оноо)

A. Хаант Орос улс

B. Зөвлөлт Орос улс

C. Манж Чин гүрэн

D. Дундад Иргэн улс

E. Япон улс

37.

37. 1911 онд Монголчууд ямар улсын эрхшээлийг түлхэн унагаж тусгаар тогтнолоо сэргээсэн бэ? (1 оноо)

A. Дундад иргэн улс

B. Хятад улс

C. Чин улс

D. БНХАУ

E. Мин улс

38.

38. 1913 оны Бээжингийн тунхаглалаар Орос, Дундад улс хоёр Монголын тусгаар тогтнолын асуудлыг хэрхэн шийдэхээр болсон бэ? (1 оноо)

- A. Бүх Монголын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрөх ёстой гэсэн шийдвэр гаргав.
- B. Ар Монголыг ДИУ-ын харьяат автономит эрхтэй гэдгийг хүлээн зөвшөөрөв.
- C. Ар Монгол Оросын, Өвөр Монгол Японы харьяаны муж байхаар шийдэв.
- D. Зөвхөн Ар Монголын бүрэн тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрөв.
- E. Ар, Өвөр Монгол дахь Японы нөлөөллийг бууруулав.

39.

39. Богд хаант Монгол улсын Дээд, Доод хурлыг ямар зарчмаар байгуулсан бэ? (1 оноо)

- A. Шашны мэдлэгийг нь харгалзан
- B. Бүх нийтийн сонгуулийн зарчмаар
- C. Яс үндэс, нутаг харгалзан
- D. Мэдлэг боловсролыг нь харгалзан
- E. Язгуур угсаа, албан тушаалыг баримтлан

40.

40. “Бурхны номын журам бадруулсан Эрдэнэт толь хэмээх шастир” хэмээх алдарт бүтээлийг туурвисан, Монголын түүхч эрдэмтэн аль нь вэ? (1 оноо)

- A. Ч.Дандаа
- B. Б.Буянчуулган
- C. Ш.Бира
- D. Н.Магсаржав
- E. Ч.Бат-Очир

41.

41. Жил бүрийн 3 сарын 18-ны өдрийг Цэргийн баярын өдөр хэмээн тэмдэглэдэг нь түүхэн ямар үйл явдалтай холбоолтой вэ? (2 оноо)

- A. Улиастайг гамин цэргээс чөлөөлсөн
- B. Хиагтыг цагаан цэргээс чөлөөлсөн
- C. Хүрээг цагаан цэргээс чөлөөлсөн
- D. Хиагтыг гамин цэргээс чөлөөлсөн
- E. Ховдыг цагаан цэргээс чөлөөлсөн

42.

42. 1918-1919 онд Д.Бодоо, Х.Чойбалсан, Д.Лосол, Д.Догсом нарын тэргүүлэн байгуулсан нууц бүлгэм Нийслэл хүрээний аль хэсэгт байрлаж байсан бэ? (1 оноо)

А. Баруун хүрээ

В. Хужирбулан

С. Усны гудамж

D. Зүүн хүрээ

Е. Консулын дэнж

43.

43. 1924 оны 11 сарын 26-нд ямар түүхэн үйл явдал болсон бэ? (2 оноо)

А. Д.Бодоо, С.Данзан нарыг хилсдүүлэн хороов.

В. VIII Богд Жавзандамбыг Хэмжээт эрхт хаанд өргөмжилсөн

С. ДИУ, Орос хоёр улс монгол улсын тусгаар тогтнолыг албан ёсоор хүлээн зөвшөөрсөн

D. Хувьсгалын оюун санааны удирдагч VIII Богд таалал болов

Е. Анхдугаар үндсэн хуулийг баталж, Бүгд найрамдах улсыг тунхагласан

44.

4. Дараах зүтгэлтнүүдийн хэн нь 1924 онд БНМАУ-ын анхны ерөнхий сайд болсон бэ? (1 оноо)

А. Б.Цэрэндорж

В. С.Данзан

С. Д.Бодоо

D. Ц.Дамбадорж

Е. П.Гэндэн

45.

45. 1931 оны Засаг захиргааны зохион байгуулалтаар 13 аймаг шинээр байгуулсан гэвэл Богд хан уулын аймгаас аль нь байгуулагдсан бэ? (1 оноо)

А. Ховд

В. Завхан

С. Увс

D. Говь-Алтай

Е. Төв

46.

46. Монголын түүхэнд зүүнтэний алдаа завхралын үе гэж тэмдэглэгдсэн түүхэн үйл явдал хэдээс хэдэн оныг хамрах вэ? (2 оноо)

A. 1922-1924 он

B. 1937-1939 он

C. 1929-1932 он

D. 1927-1930 он

E. 1956-1962 он

47.

47. Дэлхийн II дайны үед Монголчуудаас ЗОУ-д өгсөн бэлэглэлийн цувааны нэг хэсэг болох нисэх онгоцны эскадриль ямар нэртэй байсан бэ? (1 оноо)

A. Ахан дүүс

B. Монгол ард

C. Хувьсгалт Монгол

D. Ялалтын төлөө

E. Энх тайван

48.

48. Дараах онуудын алинд нь үндсэн хууль баталж байгаагүй вэ? (1 оноо)

A. 1940 он

B. 1918 он

C. 1924 он

D. 1960 он

E. 1992 он

49.

49. БНМАУ, ЗСБНХУ-ын хооронд байгуулсан "Монгол-Зөвлөлтийн харилцан туслалцах протокол"-д хэдэн онд гарын үсэг зурсан бэ? (1 оноо)

A. 1939 он

B. 1937 он

C. 1938 он

D. 1936 он

E. 1940 он

50.

50. 1945 оны 10-р сарын 20-ны өдөр болсон бүх ард түмний санал хураалт ямар асуудлаар болсон бэ? (2 оноо)

A. НҮБ-д элсэх эсэх асуудлаар

B. Монгол улсын тусгаар тогтнолын асуудлаар

C. Үндсэн хуулийн бүх нийтийн хэлэлцүүлгийн асуудлаар

D. Хөдөө аж ахуйн нэгдэл байгуулах асуудлаар

E. Чөлөөлөх дайнд оролцох эсэх асуудлаар

51.

51. 1967 онд НҮБ-ын Ерөнхий ассамблейн чуулганд төрийн тэргүүний түвшинд оролцсон удирдагч аль нь вэ? (1 оноо)

А. Л.Цэнд

В. Д.Цэвэгмид

С. Ж.Батмөнх

D. Ю.Цэдэнбал

Е. Д.Бямбасүрэн

52.

52. 1940-1950-иад оны дүрслэх урлагийн томоохон бүтээлийн нэг “Азарганы ноцолдоон” хэмээх зургийг зурсан зураач аль нь вэ? (1 оноо)

А. О.Цэвэгжав

В. Г.Одон

С. Н.Чүлтэм

D. Ү.Ядамсүрэн

Е. А.Сэнгэцохио

53.

53. 1990 оны ардчилсан хувьсгалын үед МАХН-ын Улс төрийн товчоо бүрэн бүрэлдэхүүнээрээ огцроход шийдвэрлэх үүрэг гүйцэтгэсэн зүтгэлтэн аль нь вэ? (2 оноо)

А. Р.Гончигдорж

В. Д.Бямбасүрэн

С. С.Зориг

D. П.Очирбат

Е. Ж.Батмөнх

54.

54. Монгол улсын Ерөнхий сайдуудын зөв дараалалд байгаа нь аль нь вэ? (2 оноо)

А. М.Энхсайхан, Ц.Элбэгдорж, Д.Бямбасүрэн, П.Жасрай

В. П.Жасрай, М.Энхсайхан, Ц.Элбэгдорж, Д.Бямбасүрэн

С. Д.Бямбасүрэн, П.Жасрай, М.Энхсайхан, Ц.Элбэгдорж

D. Ц.Элбэгдорж, Д.Бямбасүрэн, П.Жасрай, М.Энхсайхан

Е. Д.Бямбасүрэн, М.Энхсайхан, Ц.Элбэгдорж, П.Жасрай

55.

55. 1990 оны ардчилсан хувьсгалын үр дүнд аль нь хамааралгүй вэ?

(1 оноо)

- A. Хүний эрх, эрх чөлөөг Үндсэн хуулиар баталгаажуулсан
- B. Гадаадын цэрэг зэвсгийг нутагтаа байршуулах нөхцөл бүрэлдсэн
- C. Хүн төрөлхтний хөгжлийн нийтлэг замд шилжин орсон
- D. Олон хэвшил бүхий эдийн засагтай болсон
- E. Парламентат ёс төлөвшин тогтож байгаа

56.

56. 1992 онд Монгол улс засаг захиргааныхаа зохион байгуулалтанд тодорхой өөрчлөлт оруулан, шинээр 3 аймгийг байгуулсан билээ. Дараах аймгуудын аль нь 1992 онд байгуулагдсан бэ?

(1 оноо)

- A. Дорнод аймаг
- C. Сэлэнгэ аймаг

D. Булган аймаг

- B. Сүхбаатар аймаг
- E. Дархан-Уул аймаг

2.1.

. Доор өгүүлсэн түүхийн дурсгалуудыг он цагийн хувьд өсөх дарааллаар нь байрлуулна уу?
(5 оноо)

- a. Хойд Цэнхэрийн агуйн хадны зураг
- b. Ямаан усны хадны зураг
- c. Цамбагаравын хадны зураг
- d. Тэвш уулын хадны зураг
- e. Могоогийн хадны зураг

2.2.

2.2. Чингис хааны тэрлэн байгуулсан Их Монгол улсын төрд зүтгэж байсан хүмүүсийг аймагтай нь зөв харгалзуулна уу?
(5 оноо)

- | | |
|---------------|-------------|
| 1. Боорчи | a. Зүрчид |
| 2. Чу мэргэн | b. Арулад |
| 3. Сүбээдэй | c. Урианхай |
| 4. Хар Хирүгэ | d. Ойрад |
| 5. Борохул | e. Жүрхин |

2.3.

. Дараах он цагийг түүхэн үйл явдалтай нь зөв тохируулна уу?
(5 оноо)

- | | |
|------------|--------------------------------------|
| 1. 1648 он | a. Галдан бошгот мэндэлжээ. |
| 2. 1635 он | b. Занабазар мэндлэв. |
| 3. 1644 он | c. Намхайжамц тод үсэг зохиов. |
| 4. 1661 он | d. Зүүнгарын хаант улс байгуулагдав. |
| 5. 1676 он | e. Засагт ханы хямрал гарав. |

2.4.

. Дараах сайдуудын тэргүүлсэн засгийн газрыг хамаарах он цагтай нь зөв харгалзуулна уу?
(5 оноо)

- | | |
|-----------------------------------|-----------------|
| 1. Д.Бямбасүрэнгийн засгийн газар | а. 1990-1992 он |
| 2. П.Жасрайн засгийн газар | б. 1992-1996 он |
| 3. Ц.Элбэгдоржийн засгийн газар | с. 1996-1998 он |
| 4. Н.Энхбаярын засгийн газар | д. 2000-2004 он |
| 5. М.Энхсайханы засгийн газар | е. 2004-2006 он |

1	D	1
2	A	2
3	C	2
4	B	2
5	C	1
6	D	2
7	D	1
8	C	2
9	D	1
10	E	1
11	A	2
12	C	1
13	D	1
14	E	2
15	B	2
16	D	1
17	B	1
18	E	2
19	D	2
20	A	2
21	E	1
22	D	1
23	B	1
24	E	2
25	D	2
26	A	2
27	E	2
28	D	1

29	E	2
30	A	1
31	E	1
32	E	2
33	D	1
34	D	1
35	E	1
36	A	2
37	C	1
38	B	1
39	E	1
40	A	1
41	D	2
42	E	1
43	E	2
44	A	1
45	E	1
46	C	2
47	B	1
48	B	1
49	D	1
50	B	2
51	D	1
52	A	1
53	E	2
54	C	2
55	B	1
56	E	1

2.1	1-a	1
	2-d	1
	3-e	1
	4-c	1
	5-b	1
2.2	1-b	1
	2-a	1
	3-c	1
	4-d	1
	5-e	1
2.3	1-c	1
	2-b	1
	3-a	1
	4-e	1
	5-d	1
2.4	1-a	1
	2-b	1
	3-e	1
	4-d	1
	5-c	1